СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 | VII



www.sukhbaatar.nso.mn

www.1212.mn

Баруун-Урт сум
2024 он

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024
7 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- ‘Төл’ гэсэн нь төлөвлөгөө, ‘Гүйц’ гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь

▼ ▲ өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

• мянга	=1000	• $м^2$	метр квадрат
• сая	$=10^6$	• $км^2$	километр квадрат
• тэрбум	$=10^9$	• $м^3$	метр куб
• см	сантиметр	• мл	миллилитр
• дм	дециметр	• л	литр
• м	метр	• г	грамм
• км	километр	• кг	килограмм
• мян.	мянга	• цн	центнер
• %	хувь	• т	тонн
• кВт.ц	киловатт цаг	• ш	ширхэг
• ккал	килокалори		

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 3

Үндсэн үзүүлэлтүүд 6

I Хүн ам 7

II Хөдөлмөр 9

III Нийгмийн халамж 11

IV Эрүүл мэнд 12

V Гэмт хэрэг 15

VI Мөнгө, банк 17

VII Орон нутгийн төсөв 19

VIII Үнэ 20

IX Хөдөө аж ахуй 23

X Аж үйлдвэр 26

XI Барилга 30

Хавсралт хүснэгтийн жагсаалт 32

Хавсралт хүснэгтүүд 33

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	О.Ундрах
I Хүн ам	С.Мөнхбаяр
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V Гэмт хэрэг	Б.Сумъяа
VI Мөнгө, Банк	Б.Сумъяа
VII Орон нутгийн төсөв	С.Мөнхбаяр
VIII.а Хэрэглээний үнэ	Б.Сумъяа
VIII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	О.Ундрах
IX Хөдөө аж ахуй	О.Ундрах
X Аж үйлдвэр	Э.Анхцэцэг
XI Барилга	С.Мөнхбаяр

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

О.Ундрах

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII
Төрсөн хүүхэд	хүн	593 -28.9	747 26.0	614 -17.8
Нялхасын эндэгдэл	хүн	6 50.0	3 -50.0	5 66.6
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	351 -23.0	83 -76.4	230 2.8**
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	3 708 93.9	742 -80.0	426 -42.6
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	356 65.6	304 -14.6	300 -1.3
Хэрэгт холбогсод	хүн	261 82.5	164 -37.2	200 21.9
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	110.4 4.4	104.8 -5.1	103.2 -1.5
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	139.6 -6.7	141.1 1.1	164.1 16.3
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	198.7 27.2	223.6 12.5	284.3 27.1
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	35.0 -15.7	45.7 30.6	59.8 30.9
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	33.4 -14.6	28.2 -15.6	48.8 73.0
Тариалсан талбай:-Төмс	га	74.5 -12.1	91.2 22.4	64.5 -29.3
-Хүнсний ногоо	га	49.5 -3.7	68.2 37.8	47.4 -30.5
-Үр тариа	га	3 999.0 -26.1	4 150.0 3.8	3 867.0 -6.8
-Тэжээлийн ургамал	га	789.0 -13.5	1 251.6 58.6	2 098.0 67.6
-Техникийн ургамал	га	2 050.0 -39.5	1 400.0 -31.7	3 120.0 2.2**
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	76.4 0.6	121.6 59.2	140.0 15.1
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	177.0 21.0	269.3 52.1	220.3 -18.2

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн эхний 7 сард



Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 17.8 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2024 оны эхний 7 сард 608 эх амаржиж, 614 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 136 (18.3%)-аар, төрсөн хүүхэд 133 (17.8%)-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 7 сард



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 2.0 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 7 сард



2024 оны эхний 7 сард нас баралт 198 болж, өмнөх оноос 14 (7.6%)-аар өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 9.3, нас баралт 3.0, ердийн цэвэр өсөлт 6.3 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.2 нэгж хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд

2024 оны 7 дугаар сар

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, насны бүлгээр, тоогоор

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 9.8 хувиар буурлаа.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2024 оны 7 дугаар сарын эцэст 230 болсны 82 (35.7%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд 2023 оны 12 дугаар сарын эцсээс 72 (23.9%) хүнээр буурсан байна.

Эхний 7 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 996 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 416 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 168 (73.0%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1 (0.4%) нь магистр, доктор, 17 (7.4%) нь бакалавр, 10 (4.3%) нь тусгай дунд, 75 (32.6%) нь бүрэн дунд, 26 (11.3%) нь мэргэжлийн анхан шат, 62 (27.0%) нь суурь, 27 (11.7%) нь бага боловсролтой, 12 (5.2%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшингээр, 7 сарын байдлаар

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнөх оноос 277 (28.8%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2024 оны эхний 7 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1481 хүн хамрагдсан нь өмнөх оноос 79 (5.2%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 3523.7 сая төгрөг болж 756.3 (27.3%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2024 оны эхний 7 сард 2671 хүн хамрагдсаны 51.1 хувь нь асаргааны тэтгэмжид, 48.9 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид нийт 6745.5 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 2414.8 (33.2%) сая төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 7 сар

Үзүүлэлт	2022 I-VII		2023 I-VII		2024 I-VII	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**25 103**	**6 292.7**	**23 628**	**7 272.8**	**25 531**	**9 687.6**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	6 683	3 580.3	4 662	4 300.4	4 871	6 745.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 338	2 178.7	1 408	2 767.4	1 481	3 523.7
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 141	1 173.0	2 243	1 428.7	2 671	3 133.0
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	3 099	186.3	962	64.6	685	54.8
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 643	735.4	5 795	747.7	5 967	759.9
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 669	184.4	4 649	271.5	5 907	233.9
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2	0.3	7	0.8	8	1.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	326	66.1	340	83.1	511	107.6
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 944	1 277.7	4 926	1 369.8	4 576	1 302.2
Насны хишиг	2 836	448.5	3 249	499.5	3 691	537.0

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 685 хүн хамрагдсан нь өмнөх оноос 277(28.8%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 7 сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

2023 I-VII **9 497**

2024 I-VII **10 497**

10.5% ↑

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

2023 I-VII **742**

2024 I-VII **426**

42.6% ↓

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2023 I-VII **3**

2024 I-VII **5**

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2023 I-VII **5**

2024 I-VII **2**

2024 оны эхний 7 сарын байдлаар эхийн эндэгдэл 1 гарчээ.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2024 оны эхний 7 сард 608 эх амаржсан нь өмнөх оноос 136(18.3%)-аар буурсан байна. Нийт амаржсан эхийн 0.3 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 556(91.4%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 23(3.8%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2024 I-VII / 2023 I-VII
	тоо			хувь
Амаржсан эх	595	744	608	81.7
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	593	723	574	79.4
Гэрийн төрөлт	2	3	2	66.7
Амьд төрсөн хүүхэд	593	747	614	82.2
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	541	709	556	78.4
төрөлхийн гажигтай төрсөн	2	3	7	2.3 [1]
2500 граммаас доош жинтэй төрсөн	17	22	23	104.5
Амьгүй төрсөн хүүхэд	4	4	-	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	6.7	5.4	-	-

2024 оны эхний 7 сард нас баралтын 198 тохиолдол бүртгэгдсэний 28(14.1%) нь осол гэмтлийн улмаас, 56(28.3%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	2024 I-VII / 2023 I-VII
	тоо			хувь
Нас баралт	181	184	198	107.6
Эмнэлгийн нас баралт	39	32	42	131.3
Эхийн эндэгдэл	-	-	1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	23	38	28	73.7
Хорт хавдрын өвчлөл нас баралт	52	44	56	127.3
0-1 насны эндэгдэл	6	3	5	166.7
1-5 хүртэлх насны эндэгдэл	4	5	2	40.0

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2024 оны эхний 7 сард 426 болж, өмнөх оны мөн үеэс 316(42.6%)-аар буурахад ковид 19 болон салхинцэцэг өвчний халдварын тохиолдол буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 7 сар

Халдварт өвчин	2022 I-VII	2023 I-VII	2024 I-VII	Өсөлт	
	хүн			тоо	хувь
Бүгд	**3 708**	**742**	**426**	**- 316**	**57.4**
Вируст гепатит	3	3	1	- 2	33.3
Гар хөл амны өвчин	3	119	83	- 36	69.7
Бруцеллёз	1	-	1	1	-
Цусан суулга	10	14	11	- 3	78.6
Салхинцэцэг	7	202	132	- 70	65.3
Энтервируст халдвар	-	104	83	- 21	79.8
Гахайн хавдар	-	2	1	- 1	50.0
Улаан эсэргэнэ	-	13	-	- 13	-
Ёлом	-	1	-	- 1	-
Тархины феомикоз буглаа	-	-	1	1	-
Хачигт	-	4	1	- 3	25.0
Салмонеллт	-	15	12	- 3	80.0
Ecoli-оор/ A04.4/	-	-	3	3	-
Сүрьеэ	41	43	32	- 11	74.4
Тэмбүү	29	18	18	-	100.0
Трихомониаз	56	40	15	- 25	37.5
Заг	24	34	32	- 2	94.1
Ковид-19	3 534	130	-	- 130	-

Харин цусан суулга халдвараар өвчлөгчид 9 (4.5 дахин)-аар, салмонеллт 10 (9.0 дахин)-аар, заг хүйтэнээр өвчлөгчид 289 (33.3%)-аар нэмэгдсэн бөгөөд шинээр ecoli-оор халдарын 3 тохиолдолд тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 5 сарын байдлаар 114.9 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 2.2 (2.0%) мянган хүнээр буурч, 7.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 17.9 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 6.3 (25.9%) мянган хүнээр буурчээ.

Түргэн тусламжийн дуудлага 7.2 мянган удаа гарсны 1.6 (21.8%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 0.2 мянган (16.4%) удаагийн дуудлагаар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ, 2024 оны эхний 7 дугаар сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2023 I-VII	2024 I-VII	
304	300	1.3% ↓

Хөнгөн хэрэг
220

Хүнд хэрэг
80

Илрүүлэлтийн хувь
54.1%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
104

Нас барсан хүн
14

Хохирол сая төг
976.6

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
13

Согтуугаар
131

Ял шийтгэгдэж байсан
41

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 4 (1.3%)-өөр буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 14 хүн нас барж, 104 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 976.6 сая төгрөгийн хохирол учирсны 33.8 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 200 хүн холбогдон сэжиглэгдсэний 131 (65.5%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.
Эхний 7 сарын байдлаар нийт 190 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 155 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.
Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 54.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 11 нэгжээр өссөн байна.

Зураг 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2024 оны 7 сард

Монгол • Англи

Нийт зээлдэгчийн тоо

2023 VII **33 733**

2024 VII **36 081**

Зээл 2024 VII

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл **284.3** тэрбум төгрөг

1.7 тэрбум төгрөг Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл

1.4 тэрбум төгрөг Чанаргүй зээл

Нийт **164.1** тэрбум төгрөг

Хугацаатай **139.8** тэрбум төгрөг

Хугацаагүй **24.3** тэрбум төгрөг

Салбар нэгжийн тоо **35**

ATM-ны тоо **35**

Ажилтнуудын тоо **209**

Карт эзэмшигчийн тоо **58 514**

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 7 сарын байдлаар 1.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 284.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 10.0 (3.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 60.7 (22.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 164.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 2.0 (1.2%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 23.0 (14.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт хадгаламжийн 85.2% нь хугацаатай, 14.8 % нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 30.9 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2024 оны эхний 7 сарын байдлаар 59.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 14.1(30.7%) тэрбум төгрөгөөр өсч, төсвийн зарлага санхүүжилт 48.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 20.6(73.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум.төг



Аймгийн нийт төсвийн 30.4 хувийг орон нутгийн төсвийн орлого, 13.7 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 10.1 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 14.5 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 27.4 хувийг урьд оны үлдэгдэл тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгээ боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2024 оны 7 дугаар сард



Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай ижил түвшинд байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 7 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 5.4 хувь, өмнөх оны эцсээс 3.2 хувиар өсч, өмнөх сарын үнэтэй ижил түвшинд байна.

ЗУРАГ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 7.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 6.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 18.7 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 3.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 0.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.3 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 18.7 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 7 дугаар сард өмнөх сараас хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.5 хувь,

зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 1.2 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2024 оны 7 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2024 VII / 2023 VII	2024 VII / 2023 XII	2024 VII / 2024 VI
Ерөнхий индекс	**105.4**	**103.2**	**100.0**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	109.8	106.8	99.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.8	100.7	100.0
Хувцас, бөс бараа, гутал	107.4	102.3	100.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	101.5	100.1	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	106.6	105.6	100.6
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	104.4	102.3	100.5
Тээвэр	99.6	98.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	102.5	102.5	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	118.7	118.7	101.2
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	109.6	109.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	105.1	103.3	100.4

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2024 оны 7 дугаар сард өмнөх сараас 5.2 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ дунджаар 8.3 хувь, үхрийн махны үнэ 4.6 хувь, адууны махны үнэ 10.3 хувиар тус тус буурсан байна. Харин өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өсөхөд үхрийн махны үнэ дундажаар 23.1 хувь, хонь, ямааны махны үнэ 31.1 хувь, адууны махны үнэ 7.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.7 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2024 оны 07 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.0 сая төгрөг болж, 237.5 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.7 сая төгрөг болж, 28,6 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, 74.7 мянган төгрөгөөр тус тус буурч, эр хонины үнэ 244.5 мянган төгрөг болж, 26.2 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 152.7 мянган төгрөг болж, 17.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 10. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 7 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2024 оны 7 дугаар сард Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумдад хамгийн их буюу 2.5 сая төгрөг, Түвшинширээ суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 11. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2024 оны 7 сард, мянган төгрөг



Аргалын үнэ 2024 оны 07 дугаар сард 60.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 (18.0%) мянган төгрөгөөр, хөрзөнгийн дундаж үнэ 96.0 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 16.0 (20.0%) мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 12. АРГАЛ, ХӨРЗӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 7 сард



<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

<u>Тооцох аргачлал:</u>

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Үр тариа 3.9 мянган га-д тариалалт хийсэн байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 оны 7 дугаар сарын байдлаар төмс 64.5 га, хүнсний ногоо 47.4 га, үр тариа 3.9 мянган га, тэжээлийн ургамал 2.1 мянган га, техникийн ургамал 3.1 мянган га-д тариалсан байна.

Үр тариа 3.9 мянган га тариалсанаас 2.8 мянган га улаан буудай, 0.3 мянган га арвай, 0.8 мянган га овьёос тус тус тариалсан байна.

ЗУРАГ 21. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад техникийн ургамал 1.7 (2.2 дахин) мянган га-аар, тэжээлийн ургамал 846.4 (67.6%) га-аар тус тус өсч, төмс 26.7 (29.3 %) га-аар, хүнсний ногоо 20.6 (30.5%) га-аар, үр тариа 283.0 (6.8%) га-аар тус тус буурчээ.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эхний 7 дугаар сар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг

Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 19.0 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 7 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 140.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.4 (15.1%) тэрбум төгрөгөөр өслөө.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 7 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 117.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17.2 (17.2%) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 10.8 (19.3%) тэрбум төгрөг, бусад ашигт малтмал олборлолт 3.9 (18.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал, хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, цайрын баяжмал өмнөх оноос 3.3 хувиас 2 дахин өсчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт хэрчсэн гурил, малын мах, цэвэр ус, монгол дээл тэрлэг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5.4 хувиас 69.0 хувь хүртэл өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 VII	2023 I-VII	2024* VII	2024* I-VII	2024* I-VII / 2023 I-VII
		тоо				хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.т	51.7	525.5	82.4	728.1	138.6
Цайрын баяжмал	мян.т	5.1	41.0	6.8	42.3	103.3
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	-	1.8	-	3.6	2.0[1]
Хайлуур жонш	мян.т	0.7	5.1	2.3	9.5	183.7
Хайлуур жоншны баяжмал	мян.т	2.1	14.3	4.8	18.2	127.7
Боловсруулах аж үйлдвэр						
Талх	т	14.7	300.1	27.2	227.4	75.8
Нарийн боов	т	5.5	42.5	4.5	27.1	63.8
Хэвийн боов	т	1.0	46.3	0.5	21.6	46.6
Бялуу	т	0.3	3.8	0.4	3.2	84.0
Хэрчсэн гурил	т	0.5	39.7	7.0	53.1	133.7
Малын мах	т	118.7	610.4	0.0	762.5	124.9
Цэвэр ус	мян.л	62.9	426.8	81.8	449.7	105.4
Бууз, банш	т	1.72	15.3	0.1	9.3	60.8
Монгол дээл,тэрлэг	ш	194	1 451	400	2 452	169.0
Бэлтгэлийн хувцас /өмд, цамц/	ш	-	15	-	-	-
Гутал	хос	25	346	8	123	35.5
Бетон зуурмаг	м3	833.0	4 591.8	800	2 960.0	64.5

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2024 оны эхний 7 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 220.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 49.0 (18.2%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 50.7 (20.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая.төг

Салбар	2023 I-VII	2024*		2024* I-VII / 2023 I-VII
		I-VII	Гадаад	
	тоо			хувь
Нийт дүн	**269 307.9**	**220 348.9**	**201 848.7**	**81.8**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	247 303.0	196 561.4	195 526.2	79.5
Боловсруулах аж үйлдвэр	11 275.0	10 055.6	6 322.5	89.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	9 373.9	11 739.1	-	125.2
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1 355.9	1 992.8	-	147.0

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 50.7 (20.5%) тэрбум төгрөгөөр буурахад металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 61.9 (33.9%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 1.4 (5.4%) буурсан нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг

Гадаад зах зээлд 2024 оны эхний 7 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 201.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 196.6 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 25.6 хувийг нүүрс олборлолтын салбар, 61.6 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 12.8 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувираа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ,
2024 оны эхний 6 сарын байдлаар



Барилга угсралт, их засварын ажил өмнөх оны мөн үеэс 10.7 (38.0%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Барилгын байгууллагууд 2024 оны эхний 6 сард нийт 17.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 2.7 (15.5%) тэрбум төгрөг нь аймгийн барилгын байгууллага, 14.8 (84.5%) тэрбум төгрөг нь гадны барилгын байгууллагууд хийж гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 17. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сая төгрөг



ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД

IV.1 ЭРҮҮЛ МЭНД

IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ

V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ

V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, сумаар

V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД

V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД, сумаар

VI МӨНГӨ, БАНК

VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар

VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ

VIII.a.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

VIII.a.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ

VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, сараар

IX ХӨДӨӨ АЖ АХУЙ

IX.1 ТАРИАЛСАН ТАЛБАЙ, сумаар, га-аар

X АЖ ҮЙЛДВЭР

X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

XI БАРИЛГА

XI.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

XI.2 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, барилгын төрлөөр

XI.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сумаар

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2022		2023		2024	2024 VII / 2023 VII
	VII	XII	VII	XII	VII	
	тоо					хувь
Нийт дүн	**351**	**363**	**83**	**302**	**230**	**2.8** [1]
Асгат	7	2	1	2	12	12.0 [1]
Баяндэлгэр	7	4	-	8	-	-
Дарьганга	6	3	2	3	1	50.0
Мөнххаан	23	36	-	83	1	-
Наран	4	10	6	4	18	3.0 [1]
Онгон	15	8	2	2	-	-
Сүхбаатар	12	19	1	7	38	38.0 [1]
Түвшинширээ	9	72	7	3	17	2.4 [1]
Түмэнцогт	9	11	2	2	2	100.0
Уулбаян	9	10	-	26	3	-
Халзан	4	1	-	-	-	-
Эрдэнэцагаан	13	12	9	33	15	166.7
Баруун-Урт	233	175	53	129	123	2.3 [1]

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
	тоо															
Нийт дүн	**230**	**82**	**1**	**17**	**10**	**26**	**75**	**62**	**27**	**12**	**18**	**68**	**82**	**50**	**9**	**3**
Асгат	12	7	-	-	1	2	3	3	2	1	-	3	5	2	2	-
Баяндэлгэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-
Мөнххаан	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-
Наран	18	13	-	1	1	3	4	6	-	3	2	6	4	5	-	1
Онгон	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	38	8	-	-	1	2	6	23	1	5	1	11	15	9	2	-
Түвшинширээ	17	7	-	1	-	-	-	3	11	2	1	2	10	2	1	1
Түмэнцогт	2	2	-	-	-	2	-	-	-	-	1	1	-	-	-	-
Уулбаян	3	1	-	-	-	-	1	-	2	-	-	2	-	-	1	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	15	-	-	1	1	12	1	-	-	-	-	1	4	10	-	-
Баруун-Урт	123	44	1	14	6	5	60	25	11	1	13	40	44	22	3	1

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2022		2023		2024	2024 I-VII / 2023 I-VII
	I-VII	I-XII	I-VII	I-XII	I-VII	
	тоо					хувь
Нийт дүн	**1 243**	**2 390**	**1 088**	**1 870**	**996**	**91.5**
Асгат	52	126	54	70	65	120.4
Баяндэлгэр	15	30	4	33	-	-
Дарьганга	99	136	70	96	62	88.6
Мөнххаан	56	103	4	96	34	8.5 [1]
Наран	51	137	68	76	62	91.2
Онгон	20	41	77	135	2	2.6
Сүхбаатар	38	161	55	106	49	89.1
Түвшинширээ	163	355	177	184	58	32.8
Түмэнцогт	49	64	7	44	10	142.9
Уулбаян	17	82	19	88	16	84.2
Халзан	10	33	-	31	9	-
Эрдэнэцагаан	71	95	83	171	72	85.7
Баруун-Урт	602	1 027	470	740	557	118.5

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2022		2023		2024	2024 I-VII / 2023 I-VII
	I-VII	I-XII	I-VII	I-XII	I-VII	
	тоо					хувь
Нийт дүн	**84**	**761**	**46**	**764**	**121**	**133.8**
Асгат	36	104	49	62	38	77.6
Баяндэлгэр	2	6	1	22	-	-
Дарьганга	27	55	50	73	59	118.0
Мөнххаан	19	29	1	9	48	48.0 [1]
Наран	31	91	31	35	41	132.3
Онгон	1	17	45	97	2	4.4
Сүхбаатар	-	56	-	43	3	-
Түвшинширээ	57	153	45	48	34	75.6
Түмэнцогт	19	21	-	32	-	-
Уулбаян	2	38	1	44	10	10.0 [1]
Халзан	4	24	-	31	9	-
Эрдэнэцагаан	4	11	61	114	36	59.0
Баруун-Урт	66	156	27	154	136	5.0 [1]

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар									
	2023 I-VII	2024 I-VII				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Боловсруулах аж үйлдвэр	Барилга	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам
		Бүгд	Үүнээс												
			Байн-гын	Түр	Улирал										
	тоо														
Нийт дүн	**694**	**312**	**80**	**219**	**13**	**36**	**32**	**1**	**2**	**1**	**1**	**217**	**8**	**1**	**2**
Асгат	61	38	8	30	-	5	-	-	-	1	-	30	2	-	-
Баяндэлгэр	6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	112	54	9	43	2	2	-	-	-	-	-	44	6	-	2
Мөнххаан	44	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	74	29	7	22	-	-	-	-	-	-	-	22	-	1	-
Онгон	15	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	11	2	2	-	-	-	-	-	-	-	-	2	-	-	-
Түвшинширээ	87	51	20	28	3	13	10	-	-	-	-	28	-	-	-
Түмэнцогт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	-	24	1	20	3	-	-	-	-	-	-	24	-	-	-
Халзан	-	67	-	67	-	-	-	-	-	-	-	67	-	-	-
Эрдэнэцагаан	170	19	18	-	1	15	1	-	2	-	1	-	-	-	-
Баруун-Урт	114	28	15	9	4	1	21	1	-	-	-	-	-	-	-

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2022 I-VII		2023 I-VII		2024 I-VII	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**25 103**	**6 292.7**	**23 628**	**7 272.8**	**25 531**	**9 687.6**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**6 683**	**3 580.3**	**4 662**	**4 300.4**	**4 871**	**6 745.5**
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 338**	**2 178.7**	**1 408**	**2 767.4**	**1 481**	**3 523.7**
Нийгмийн халамжийн тэтгэмж	**2 141**	**1 173.0**	**2 243**	**1 428.7**	**2 671**	**3 133.0**
Асаргааны тэтгэмж	**1 128**	**663.1**	**1 140**	**852.9**	**1 364**	**2 430.7**
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	218	112.5	200	143.7	232	417.8
Байнгын асаргаа шаардлагтай ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	637	333.6	672	451.5	833	1 444.8
Байнгын асаргаа шаардлагтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	229	188.5	228	224.5	261	478.6
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	18	12.3	17	14.6	15	40.6
Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	5.2	7	7.3	8	19.5
Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	21	11.0	16	11.3	15	29.4
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	**1 013**	**509.9**	**1 103**	**575.8**	**1 307**	**702.3**
